



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 613

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн 805 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 21,916,060.00 (хорин нэгэн сая есөн зуун арван зургаан мянга жаран) төгрөгийн балансын үнэ, 18,688,268.37 (арван найман сая зургаан зуун наян найман мянга хоёр зуун жаран найман төгрөг гучин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 7 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Худалдсан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006970

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 1 дугаар сарын 15-ны өдрийн
6/12 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ДОТООДЫН ЦЭРГИЙН 805 ДУГААР АНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини нэр, марк, улсын дугаар, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Шинэчлэн тогтоосон хугацаа (огноо)	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ-315122, 08-50 УБЦ (арал-70566327)	2006.06.11	2019.12.30	244367	2,908,500.00	2,908,500.00	-	870,000.00
2	Аксент, 04-51 УНУ (арал-кмhcm41ap8u276600)	2008.10.01	2019.12.30	266149	5,140,620.00	5,140,620.00	-	1,540,000.00
3	Элентра, 00-28 УБЛ (арал-кмhdu41bp8u540064)	2008.10.01	2019.12.30	283774	6,238,440.00	6,238,440.00	-	1,870,000.00
4	УАЗ-39629, 80-23 УНП (арал-60405423, 60489036)	2006.08.25	2019.12.30	318302	180,000.00	180,000.00	-	500,000.00
5	УАЗ-22069, фургон, 40-47 УБВ (арал-60702532, 70498439)	2007.01.29	2019.12.30	218480	3,388,500.00	2,164,875.00	1,223,625.00	1,250,000.00
6	Аксент, 15-44 УБЛ (арал-КМНCL41 AP9U365772)	2009.04.30	2019.12.30	195390	360,000.00	360,000.00	-	500,000.00
7	УАЗ-22069, фургон, 48-73 УНЕ (арал-90003935, 0405857)	2010.08.01	2020.12.31	179188	3,700,000.00	1,695,833.37	2,004,166.63	2,000,000.00
Нийт дүн					21,916,060.00	18,688,268.37	3,227,791.63	8,530,000.00
					(хорин нэгэн сая есөн зуун арван зургаан мянга жаран)	(арван найман сая зургаан зуун наян найман мянга хоёр зуун жаран найман төгрөг гучин долоон мөнгө)	(гурван сая хоёр зуун хорин долоон мянга долоон зуун ерөн нэгэн төгрөг жаран гурван мөнгө)	(найман сая таван зуун гучин мянга)